

# БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: БНА-2024/172/НА- СТА-ТШЗ

Цахим хуудас: <a href="#">www.audit.mn</a> Баянхонгор хот 2024 оны 02 дугаар сарын 06-ны өдөр	Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын Дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат Утас: 70442584 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Ахлах аудитор М.Алтантуяа Утас: 70442424 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn Ахлах аудитор Б.Должмаа Утас: 88110538 Цахим хаяг: doljmaab@audit.gov.mn
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	3
Аудитын гол асуудал .....	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ .....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	11
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл .....	14
4.2 Материаллаг байдал .....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал .....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	15
4.5.1 Завсрын аудитын талаар .....	15
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ОНӨААТҮГ	Орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн  
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,  
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101  
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement.bayankhongor@audit.gov.mn

2024.02.06 № 2/02

танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийн дүн нь гүйцэтгэлийн үе шатанд тооцсон материаллаг байдлын дүнгээс хэтэрсэн;
- Байгууллагын даргаар ажиллаж байсан П.Уртнасан 3,840,000 төгрөгийн 4 тонн улаан хивгийг эргэн төлөхөөр авсан байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан;
- Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланд бүртгэлтэй "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699,500 төгрөгийн авлагыг барагдуулах талаар анхаарч авч үзэх талаар санхүүгийн тайланд дурдсан байхад тус байгууллагаас ямар нэгэн арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 13.4 дэх "Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна", 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага", 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтууд

5020059

болон УСНББОУС 17 болон Оршин байх, Тохиолдсон байх, Иж бүрэн байх, Үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

### **Асуудлыг онцолсон хэсэг**

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй, 2023 онд 71703 (Ойжуулалт) хөтөлбөрийн 2 арга хэмжээний зардалд 152,859.3 мянган төгрөгийн санхүүжилт батлагдсаныг бүрэн авч, туслах ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэн 5,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

### **Аудитын гол асуудал**

Дуслын усалгааны системийг хүлэмж бүрд байршуулж агч, монос, гүйлс, жигд, хайлаас гэсэн 5 төрлийн модны үрийг 4 хүлэмжид стандартын дагуу суваглан тариалсан бөгөөд 5 дугаар сард мод үржүүлгийн газарт 4.3 га газар 48,000 ширхэг харандаан суулгац суулгасан, сувгийн усалгааг 2.6 га талбайд тарилт хийж гүйцэтгэсэн байна.

### **Бусад асуудлын хэсэг**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 3 бүлгийн хүрээнд 21 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусган хэрэгжүүлэн, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг 100 хувьтай тайлагнаж, аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтэст хүргүүлсэн, үнэлгээ хийгдээгүй байна.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2023 оны санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй, аудитад ажил гүйлгээг түүврийн аргыг ашиглан гүйцэтгэсэн болно.

### **Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### **Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ  
АУДИТОР



Б.МӨНХБАТ

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>448,506,072.88</b>	<b>745,611,660.00</b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	<b>94,567,692.88</b>	<b>76,814,500.00</b>
<b>33500</b>	<b>Бусад авлага</b>	<b>94,567,692.88</b>	<b>76,814,500.00</b>
33510	Байгууллагаас авах авлага	20,868,192.88	3,115,000.00
33520	Хувь хүмүүсээс авах авлага	73,699,500.00	73,699,500.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	<b>353,938,380.00</b>	<b>668,797,160.00</b>
<b>35400</b>	<b>Хангамжийн материал</b>	<b>353,938,380.00</b>	<b>668,797,160.00</b>
35410	Бичиг хэргийн материал	926,600.00	2,440,500.00
35420	Аж ахуйн материал	8,057,400.00	8,057,400.00
35470	Бусад хангамжийн материал	344,954,380.00	658,299,260.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b>505,295,149.39</b>	<b>445,360,480.39</b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	<b>505,295,149.39</b>	<b>445,360,480.39</b>
<b>39200</b>	<b>Биет хөрөнгө</b>	<b>433,164,349.39</b>	<b>373,229,680.39</b>
39201	Барилга, байгууламж, орон сууц	91,391,450.00	91,391,450.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-11,471,656.90	-17,697,346.78
39203	Авто-тээврийн хэрэгсэл	340,024,914.30	340,024,914.30
39204	Хуримтлагдсан элэгдэл	-62,171,525.55	-104,875,677.99
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	35,259,486.00	35,259,486.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-14,856,236.48	-20,160,636.44
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,793,459.00	1,793,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-695,959.02	-1,059,292.38
39214	Бусад үндсэн хөрөнгө	54,779,933.60	54,779,933.60
39215	Хуримтлагдсан элэгдэл	-889,515.56	-6,226,608.92
<b>39300</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	<b>72,130,800.00</b>	<b>72,130,800.00</b>
39301	Программ хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-836,000.00	-836,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	72,130,800.00	72,130,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b>953,801,222.27</b>	<b>1,190,972,140.39</b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>200,799,500.00</b>	<b>200,014,000.00</b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>200,799,500.00</b>	<b>200,014,000.00</b>
<b>41300</b>	<b>Өглөг</b>	<b>200,799,500.00</b>	<b>200,014,000.00</b>
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	785,500.00	0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	200,014,000.00	200,014,000.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>753,001,722.27</b>	<b>990,958,140.39</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	<b>753,001,722.27</b>	<b>990,958,140.39</b>
51100	Засгийн газрын оруулсан капитал	211,388,886.00	211,388,886.00
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	211,388,886.00	211,388,886.00
<b>51200</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>541,612,836.27</b>	<b>779,569,254.39</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	201,129,110.33	534,402,136.27
51220	Тайлант үеийн үр дүн	340,483,725.94	245,167,118.12
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>953,801,222.27</b>	<b>1,190,972,140.39</b>

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>607,380,717.90</b>	<b>646,984,300.00</b>
12	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>483,805,917.90</b>	<b>487,205,000.00</b>
120	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>483,805,917.90</b>	<b>487,205,000.00</b>
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>8,000,000.00</b>	<b>0</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	0
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	203,746,097.90	0
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	272,059,820.00	487,205,000.00
13	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>123,574,800.00</b>	<b>159,779,300.00</b>
1311	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>16,328,000.00</b>	<b>6,920,000.00</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	16,328,000.00	6,920,000.00
1320	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>107,246,800.00</b>	<b>152,859,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,246,800.00	152,859,300.00
II	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>264,928,991.96</b>	<b>401,817,181.88</b>
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>264,928,991.96</b>	<b>401,817,181.88</b>
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>260,464,253.65</b>	<b>388,234,315.59</b>
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>82,718,099.69</b>	<b>119,339,866.59</b>
210101	Үндсэн цалин	79,614,499.69	101,799,866.59
210102	Нэмэгдэл	0	11,006,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,103,600.00	6,534,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,754,600.00</b>	<b>15,020,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,313,100.00	10,213,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	860,400.00	1,201,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	688,300.00	961,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	172,100.00	240,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,720,700.00	2,403,200.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,050,000.00</b>	<b>5,750,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,050,000.00	5,750,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>34,174,775.00</b>	<b>29,014,800.00</b>
210401	Бичиг хэрэг	843,500.00	486,100.00
210402	Тээвэр, шатахуун	2,896,000.00	6,444,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	210,800.00
210408	Бараа материал акалсны зардал	30,255,275.00	21,873,300.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>684,000.00</b>	<b>1,409,000.00</b>
210604	Урсгал засвар	684,000.00	1,409,000.00
2107	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,250,000.00</b>	<b>1,250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	1,250,000.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>31,985,362.00</b>	<b>154,455,780.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	31,406,500.00	154,108,520.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,000.00	71,000.00

210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	280,862.00	144,260.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>96,847,416.96</b>	<b>61,994,669.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	58,665,740.00	2,060,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	38,181,676.96	59,934,669.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>4,464,738.31</b>	<b>13,582,866.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,045,600.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,045,600.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>419,138.31</b>	<b>12,582,866.29</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	419,138.31	12,582,866.29
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)</b>	<b>342,451,725.94</b>	<b>245,167,118.12</b>
<b>V</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>1,968,000.00</b>	<b>0</b>
225010	Үнэ төлбөргүй гарсан зардал - Үндсэн хөрөнгө	1,968,000.00	0
<b>VI</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)</b>	<b>340,483,725.94</b>	<b>245,167,118.12</b>

### 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
<b>I</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>161,679,292.88</b>	<b>170,321,792.88</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>8,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	<b>8,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
<b>120004</b>	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	<b>8,000,000.00</b>	<b>5,000,000.00</b>
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	8,000,000.00	5,000,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>153,679,292.88</b>	<b>165,321,792.88</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>46,432,492.88</b>	<b>12,462,492.88</b>
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,432,492.88	12,462,492.88
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	<b>107,246,800.00</b>	<b>152,859,300.00</b>
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	107,246,800.00	152,859,300.00
<b>II</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>160,309,292.88</b>	<b>170,321,792.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>160,309,292.88</b>	<b>170,321,792.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>145,302,061.69</b>	<b>156,738,926.59</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	<b>81,932,599.69</b>	<b>120,125,366.59</b>
210101	Үндсэн цалин	78,828,999.69	102,585,366.59
210102	Нэмэгдэл	0	11,006,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,103,600.00	6,534,000.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	<b>10,754,600.00</b>	<b>15,020,200.00</b>
210201	Тэтгэврийн даатгал	7,313,100.00	10,213,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	860,400.00	1,201,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	688,300.00	961,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	172,100.00	240,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,720,700.00	2,403,200.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	<b>2,050,000.00</b>	<b>5,750,000.00</b>
210301	Гэрэл, цахилгаан	2,050,000.00	5,750,000.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	<b>4,376,000.00</b>	<b>8,655,400.00</b>
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	2,000,000.00

210402	Тээвэр, шатахуун	2,896,000.00	6,444,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	180,000.00	210,800.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	<b>470,000.00</b>	<b>5,590,700.00</b>
210601	Багаж, техник, хэрэгсэл	260,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	210,000.00	1,590,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	<b>1,250,000.00</b>	<b>1,250,000.00</b>
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	1,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	<b>42,468,862.00</b>	<b>347,260.00</b>
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	41,890,000.00	0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	199,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	99,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	280,862.00	144,260.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>2,000,000.00</b>	<b>0</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,000,000.00	0
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>15,007,231.19</b>	<b>13,582,866.29</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>4,045,600.00</b>	<b>1,000,000.00</b>
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,045,600.00	1,000,000.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>10,961,631.19</b>	<b>12,582,866.29</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	419,138.31	120,373.41
213405	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	10,542,492.88	12,462,492.88
<b>III</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)</b>	<b>1,370,000.00</b>	<b>0</b>
<b>V</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)</b>	<b>1,370,000.00</b>	<b>0</b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>1,370,000.00</b>	<b>0</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1,370,000.00</b>	<b>0</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,370,000.00	0
<b>VI</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)</b>	<b>-1,370,000.00</b>	<b>0</b>
<b>VIII</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)</b>	<b>0</b>	<b>0</b>
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0

#### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	200,741,110.33	412,517,996.33
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	388,000.00	388,000.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	388,000.00	201,129,110.33	412,905,996.33
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	-388,000.00	0	-388,000.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0

6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
7	Өмчид гарсан өөрчилөлт	0	0	0	0
8	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
9	Тайлант үеийн үр дүн	0	0	340,483,725.94	340,483,725.94
10	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	0	541,612,836.27	753,001,722.27
11	2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	211,388,886.00	0	541,612,836.27	753,001,722.27
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0	0	-7,210,700.00	-7,210,700.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	211,388,886.00	0	534,402,136.27	745,791,022.27
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0	0	0	0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0	0	0	0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0	0	0	0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0	0	0	0
18	Зарласан ногдол ашиг	0	0	0	0
19	Тайлант үеийн үр дүн	0	0	245,167,118.12	245,167,118.12
20	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	0	779,569,254.39	990,958,140.39

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	157,859,300.00	157,738,926.59
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	157,859,300.00	157,738,926.59
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	156,859,300.00	156,738,926.59
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	120,162,000.00	120,125,366.59
210101	Үндсэн цалин	102,622,000.00	102,585,366.59
210102	Нэмэгдэл	11,006,000.00	11,006,000.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	6,534,000.00	6,534,000.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	15,020,200.00	15,020,200.00
210201	Тэтгэврийн даатгал	10,213,800.00	10,213,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,201,600.00	1,201,600.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	961,300.00	961,300.00
210204	Ажилгүйдлийн даатгал	240,300.00	240,300.00
210205	Эрүүл мэндийн даатгал	2,403,200.00	2,403,200.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	5,750,000.00	5,750,000.00
210301	Гэрэл, цахилгаан	5,750,000.00	5,750,000.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	8,655,400.00	8,655,400.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,000,000.00
210402	Тээвэр, шатахуун	6,444,600.00	6,444,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	210,800.00	210,800.00

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	5,590,700.00	5,590,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,000,000.00	4,000,000.00
210604	Урсгал засвар	1,590,700.00	1,590,700.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	1,250,000.00	1,250,000.00
210702	Дотоод албан томилолт	1,250,000.00	1,250,000.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	431,000.00	347,260.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	99,000.00	71,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	132,000.00	132,000.00
210807	Газрын төлбөр	200,000.00	144,260.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1000000.00	1000000.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,000,000.00	1,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,000,000.00	1,000,000.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	157,859,300.00	157,859,300.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	152,859,300.00	152,859,300.00
132001	Орон нутгийн төсвөөс	152,859,300.00	152,859,300.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	5,000,000.00	5,000,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	5,000,000.00	5,000,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	11.00	10.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	09.00	08.00
620003	Үйлчлэх ажилтан	01.00	01.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	11.00	10.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>12,462,492.88</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>12,462,492.88</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	12,462,492.88
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	12,462,492.88
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	12,462,492.88
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	12,462,492.88
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	12,462,492.88
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	12,462,492.88
<b>IV</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)</b>	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги нь "Мод, тарьц, суулгацыг үржүүлж, аймгийн ногоон байгууламжид нийлүүлэх" эрхэм зорилготой, 2023 онд 11 орон тоотой үйл ажиллагаа явуулсан байна.

Тайлант онд хөрөнгө захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг 2023.01.01-2023.10.11-ний өдрийг хүртэл дарга П.Уртнасан, 2023.10.12-2023.12.31-ний өдөр хүртэл дарга Б6Дэлгэрдалай нар зурсан, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч А.Нямхүү нар зуржээ. Харин нярваар М.Мөнгөнцэцэг 2023 оны 1-6 сард ажиллаж байгаад ажлаас чөлөөлөгдөж, Н.Ундрахбуян 2023 оны 11 дүгээр сараас нярваар томилогдон ажиллаж байна.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

Байгууллага нь Төсвийн тухай, Төрийн албаны тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай, Хөдөлмөрийн тухай, Ойн тухай, Мэдээллийн ил тод байдлын тухай, Шилэн дансны тухай, Төрийн хэмнэлтийн тухай, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай, Байгууллагын нууцын тухай, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай, Гамшгаас хамгаалах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай, Зөрчлийн тухай, Нийгмийн даатгалын тухай, Архивын тухай, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон Татварын багц хуулиудыг мөрдөж үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулийг үргэлжлүүлэн мөрдсөн;
- Засгийн газрын 2023 оны 240, 241 дүгээр тогтоолоор албан хаагчдын цалин нэмэгдсэн байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авсан ба дотоод аудит гүйцэтгээгүй тул аудитад ашиглах баримт материал байхгүй, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын үйл ажиллагаанд мөрдөж буй Баянхонгор аймгийн СТСХ-ээс бэлтгэж гаргасан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 237,170.9 мянган төгрөгөөр буюу 124.8 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
A	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	-	0
Авлага	94,567.7	76,814.5	(17,753.2)
Бараа материал	353,938.4	668,797.2	314,858.8
Үндсэн хөрөнгө	596,216.0	596,216.0	0
Хуримтлагдсан элэгдэл	(90,920.9)	(150,855.6)	(59,934.7)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>953,801.2</b>	<b>1,190,972.2</b>	<b>237,171.0</b>
Өр төлбөр	200,799.5	200,014.0	(785.5)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	753,001.7	990,958.1	237,956.4
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>953,801.2</b>	<b>1,190,972.1</b>	<b>237,170.9</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн санхүүгийн тайлан

Дээрх хүснэгтээс харахад Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн 2022 оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан дансанд нь авлага, бараа материалын данс байна.

Санхүүгийн тайлангийн оны эхний авлагаас Баянцагаан сумын ЗДТГ-тай холбоотой 3,115.0 мянган төгрөгийг шүүхэд шилжүүлж, 2023.09.13-ны өдрийн 131/ШШ2023/00718 дугаар шүүгчийн захирамжаар 2024.05.30-ны дотор төлөхөөр шийдвэрлэсэн тул заасан хугацаанд барагдуулж ажиллахад байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар анхаарч ажиллах нь зүйтэй байна.

Хүснэгт 2. Авлагын судалгаа (мянган төгрөгөөр)

№	Байгууллагын нэр	Эхний үлдэгдэл	Нэмэгдсэн	Барагдсан	Эцсийн үлдэгдэл
1	"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ	73,699.50	-	-	73,699.50
2	Бууцагаан сум	4,388.50	-	4,388.50	-
3	Баацагаан сум	1,650.00	-	1,650.00	-
4	Баян-Өндөр сум	1,172.20	-	1,172.20	-
5	Баянцагаан сум	3,115.00	-	-	3,115.00
6	Гурванбулаг сум	-	-	-	-
7	Оны эцэст төвлөрүүлсэн орлогын авлага	10,542.49	-	10,542.49	-
	<b>Дүн</b>	<b>94,567.69</b>	<b>-</b>	<b>17,753.19</b>	<b>76,814.50</b>

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн ерөнхий дэвтэр

Санхүүгийн тайланд бүртгэлтэй авлагын 95.9 хувь буюу 73,699.5 мянган төгрөгийн авлага нь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-ын 2017-2020 онд үүссэн иргэн, сумдад олгосон өвс, тэжээлийн авлага байгаа ба тус авлагыг барагдуулах талаар тухайн байгууллагын төсвийн захирагч, нягтлан бодогч нар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 314,858.8 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь байгууллагын даргын 2023.12.11-ний өдрийн А/11 дүгээр тушаалаар өмнөх онд мод

үржүүлгийн талбайд харандаан тайраадасаар тариалсан улиас, бургас, улаан сухайг зах зээлийн үнэ ханшаар тооцож, бүртгэлд тусгасантай холбоотой байна.

Тайлант онд үндсэн хөрөнгө, өглөгийн дансанд өөрчлөлт ороогүй байна. Өмнөх оны санхүүгийн тайланд бүртгэлтэй 200,000.0 мянган төгрөгийн өглөг нь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-аас шилжиж ирсэн өглөг байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл тайлант үеийн үр дүнгийн 237,956.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, 990,958.1 мянган төгрөг болсон байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 220,566.4 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 5,000.0 мянга, нийт зарлагыг 225,566.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас орон нутгийн төсвөөс авах санхүүжилтийг 81,918.1 мянган төгрөгөөр бууруулж, 138,648.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь бараа үйлчилгээний зардлыг (мод бутны суулгац, жимсний үр худалдан авах) 20,000.0 мянга, урсгал зардлыг 35,000.0 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардлаас 7,200.0 мянга, бусад урсгал зардлаас 5,507.1 мянган төгрөгийг хасч баталснаас шалтгаалсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсвийг 19,211.2 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 71403 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 152,859.3 мянга төгрөгийг орон нутгийн төсвөөс, 5,000.0 мянган төгрөгийг туслах ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 152,859.3 мянган төгрөгийн санхүүжилт олгож, туслах ажиллагааны орлогын төлөвлөгөөг бүрэн биелүүлэн 5,000.0 мянган төгрөгийг төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 157,738.9 мянган төгрөг буюу нийт төлөвлөсөн зардлын 99,9 хувьтай байгаа ба цалингийн зардлыг 36.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 83.7 мянган төгрөгөөр хэмнэснийг оны эцэст 120.3 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт 3. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл (мянган төгрөгөөр)*

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	120,162.00	120,125.40	36.60	100.0
2	Ажил олгогчоос төлөх НДШ	15,020.00	15,020.00	0.00	100.0
3	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,750.00	5,750.00	0.00	100.0
4	Хангамж бараа материалын зардал	8,655.40	8,655.40	0.00	100.0
5	Эд хогшил, урсгал засварын зардал	5,590.70	5,590.70	0.00	100.0
6	Томиллолт, зочны зардал	1,250.00	1,250.00	0.00	100.0

7	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж	431.00	347.26	83.74	94.0
8	Ажил олгогчоос олгох тэтгэмж	1,000.00	1,000.00	0.00	100.0
	ДҮН	157,859.10	157,738.76	120.34	

Эх сурвалж: Баянхонгор аймгийн Сум дундын Ойн ангийн төсвийн хэлбэлзэл

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансаар өмнөх оны санхүүжилтийн 10,542.5 мянган төгрөгийн авлага барагдсан, 2023 оны 01 дүгээр сард худалдан борлуулсан өвс тэжээлийн орлогын 1,920.0 мянга, нийт 12,462.5 мянган төгрөгийн орлого орсныг оны эцэст орон нутгийн дансанд төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангид худалдан авах ажиллагаа байхгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Должмаа гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Баянхонгор аймгийн Сум дундын Ойн анги 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 06 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

## **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант жилийн батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлж, материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 157,738.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 1,577.4 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 1,104.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжүүлэн ажилласан байна.

## **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Нийцлийн асуудлаар илэрсэн нийт 10,026.3 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага өглөө.

### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаас таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,026,300 (Арван сая хорин зургаан мянга гурван зуун) төгрөгийн орлогын нэг гүйлгээ болон тайлант онд байгуулсан 2 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаас байршуулаагүй орхигдуулсан байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаас орхигдуулсан орлого болон гэрээнүүдийг нөхөн мэдээлэх албан шаардлагыг өгсөн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

## **4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

### **4.5.1 Завсрын аудитын талаар**

Тус байгууллагад завсрын аудитыг гүйцэтгээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар "Хязгаарлалттай" дүгнэлт авч, аудитын тайлангаар 38,933.5 мянган төгрөгийн 3 шийдвэрийг өгсөн, хэрэгжилтийг санхүүгийн тайлангийн FAS системд оруулж, албан бичгээр хариуг ирүүлж, бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Хүснэгт 4. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт (мянган төгрөгөөр)

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	10,325.70	1	10,325.7	100
Албан шаардлага	1	30,255.30	1	30,255.30	100
Зөвлөмж	1	1,467.50	1	1,467.50	100
Залруулга	3	54,501.40	3	54,501.40	100
<b>Нийт дүн</b>	<b>6</b>	<b>96,549.90</b>	<b>6</b>	<b>96,549.90</b>	<b>100</b>

Эх сурвалж: Санхүүгийн тайлангийн FAS систем, ирүүлсэн холбогдох баримт, материал

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт үнийн дүнгүй нэг алдаа<sup>1</sup> илэрснээс аудитын явцад богино хугацаат өр төлбөрийн тодруулга тайланд алдааг залруулав.

Залруулсан алдаа:

- Байгууллагын нягтлан бодогч цалин, цахилгааны зардлыг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд тайлагнасан байгаа нь Иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй тул залруулсан.

Аудитаар нийт 77,539.5 мянган төгрөгийн 2 зөрчил<sup>2</sup> илэрснээс, 3,840.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 73,699.5 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлсэн.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 3,840.0 мянган төгрөгийн залруулагдаагүй зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 2,735.8 мянган төгрөгөөр давсан тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.

#### 5.1 Төлбөрийн акт

Байгууллагын нярав солигдож ажил хүлээлцэх үеэр байгууллагын хөрөнгийг тоолж, даргаар ажиллаж байсан П.Уртнасан 3,840.0 мянган төгрөгийн уут буюу 4 тонн улаан хивгийг эргэн төлөхөөр авсан байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн захирагчаар ажиллаж байсан П.Уртнасангаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

<sup>1</sup> Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

<sup>2</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

## 5.2 Албан шаардлага

Тус байгууллагын санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Байгууллагын санхүүгийн тайлан дахь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой авлагыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэх албан шаардлагыг өгөв.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан нягтлан бодогчид талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл (мянган төгрөгөөр)

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Байгууллагын нягтлан бодогч цалин, цахилгааны зардлыг өглөгийн дансаар дамжуулалгүй шууд зардалд тайлагнасан байна.	1	-					1	-				
Дүн	1	-	0	0	0	0	1	-	0	0	0	0

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл (мянган төгрөгөөр)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Байгууллагын нярав солигдож ажил хүлээлцэх үеэр байгууллагын хөрөнгийг тоолж, даргаар ажиллаж байсан П.Уртнасан 3,840.0 мянган төгрөгийн 160 уут буюу 4 тонн улаан хивэгийг авч, эргэн нөхөн өгөх байсан ч хивэгийг одоо болтол өгөөгүй, санхүүгийн тайланд үлдэгдлээр бүртгэлтэй байна.	1	3,840.0	1	3,840.0								
"Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699.5 мянган төгрөгийн авлагыг барагдуулах	1	73,699.5			1	73,699.5						

талаар хэмжээ ажиллаагүй байна.	арга авч												
Дүн	2	77,539.5	1	3,840.0	1	73,699.5	0	-	0	0	0	0	0

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал (мянган төгрөгөөр)**

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,026.3 мянган төгрөгийн орлогын нэг гүйлгээ болон тайлант онд байгуулсан 2 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.	1	10,026.3			1	10,026.3		
Дүн	1	10,026.3	0	0	1	10,026.3	0	

---oOo---



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 06/А0560238/БНА  
2024/172/НА.СТА-ТМБ

Номгон

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нярав солигдож ажил хүлээлцэх үеэр байгууллагын хөрөнгийг тоолж, даргаар ажиллаж байсан П.Уртнасан 3,840,000 (Гурван сая найман зуун мянга) төгрөгийн 160 уут буюу 4 тонн улаан хивгийг эргэн төлөхөөр авсан байхад санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй, бараа материалын үлдэгдлээр тайлагнасан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх “Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно”, 13.4 дэх “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 14 дүгээр зүйлийн 14.4.2 дахь “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь “Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно”, Монгол Улсын

D/2024-Akt

5050019

Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.7 дахь “Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгийг дутаасан, үрэгдүүлсэн, хууль бусаар ашигласан”, 4.2.3.8 дахь “Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 2.1.2-т заасан бусад нөхцөл байдал үүссэн” гэснийг тус тус үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Санхүүгийн тайланд бараа материалын үлдэгдлээр тайлагнасан 3,840,000 (Гурван сая найман зуун мянга) төгрөгийн бараа материалын үнийг байгууллагын төсвийн захирагчаар ажиллаж байсан П.Уртнасангаар төлүүлж, Төрийн сан дахь 100030000947 тоот төгрөгийн дансанд төвлөрүүлэх.
2. Аудитаар тогтоосон төлбөрийн актыг бүрэн барагдуулж, нотлох баримтыг 2024 оны 03 дугаар сарын 20-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> ирүүлэхийг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга Б.Дэлгэрдалай, нягтлан бодогч А.Нямхүү нарт даалгав<sup>2,3</sup>.

#### **ТӨЛБӨРИЙН АКТЫГ ТОГТООСОН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА,  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АХЛАХ АУДИТОР

Б.МӨНХБАТ  
Б.ДОЛЖМАА

8417143544  
Б-ОА0067 9007423

<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 “Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана”

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын 5.5 “Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй”

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 04/АОСБ0238/БАА  
2024/172/НА - СТА - ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Байгууллагын нягтлан бодогч шилэн дансны нэгдсэн цахим хуудаст таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 10,026,300 (Арван сая хорин зургаан мянга гурван зуун) төгрөгийн орлогын нэг гүйлгээ болон тайлант онд байгуулсан 2 гэрээг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулаагүй орхигдуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 дахь “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ: цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр” гэснийг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх “Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө”, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх “хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал” гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Байгууллагын шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 10,026,300 (Арван сая хорин зургаан мянга гурван зуун) төгрөгийн орлого, гэрээнүүдийг нөхөн мэдээлж,

5040010

D/2024-ASH

нотлох баримтыг FAS системд оруулж, нотлох баримтыг 2024 оны 02 дугаар сарын 29-ний дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>1</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга Б.Дэлгэрдалай, нягтлан бодогч А.Нямхүү нарт даалгав<sup>2,3</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>4</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>1</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>2</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>3</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>4</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 06 өдөр

Дугаар 05/2/АОСӨА/238/БНА  
2024/ТХ/НА-СГА-ТМЗ

Номгон

ЗӨРЧИЛ АРИЛГАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд тодорхойлсон Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллагын санхүүгийн тайланд авлагаар бүртгэсэн "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699,500 (Далан гурван сая зургаан зуун ерэн есөн мянга таван зуун) төгрөгийн авлагыг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8 дахь "Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "Ерөнхий нягтлан бодогч дараах үүрэг хүлээнэ: дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", 6.6.1 дэх "Энэ хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: 6.6.1.төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх" гэснийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.1.11 дэх "хууль, тогтоомж гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэснийг тус тус үндэслэн **ШААРДАХ нь:**

**5040015**

1. Байгууллагын санхүүгийн тайлан дахь "Хонгор шинэ агро" ОНӨААТҮГ-тай холбоотой 73,699,500 (Далан гурван сая зургаан зуун ерэн есөн мянга таван зуун) төгрөгийн авлагыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлж, нотлох баримтыг 2024 оны 02 дугаар сарын 28-ны дотор Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх<sup>5</sup>

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга Б.Дэлгэрдалай, нягтлан бодогч А.Нямхүү нарт даалгав<sup>6,7</sup>.

**АЛБАН ШААРДЛАГЫГ ӨГСӨН<sup>8</sup>:**

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН  
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:

Б.МӨНХБАТ

АХЛАХ АУДИТОР:

Б.ДОЛЖМАА



<sup>5</sup> Монгол Улс, Баянхонгор аймаг, Баянхонгор сум, Нутгийн удирдлагын ордон 3 давхар

<sup>6</sup> Захиргааны ерөнхий хуулийн 94 дүгээр зүйлийн 94.1 "Захиргааны актыг энэ хуульд заасан журмын дагуу мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор гомдлыг хянан шийдвэрлэх захиргааны байгууллагад гаргана."

<sup>7</sup> Монгол улсын ерөнхий аудиторовын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 5.5 "Аудитад хамрагдагч нь аудитын тайлангийн төслийн өөрт холбогдох хэсэгтэй танилцах, санал өгөх, албан шаардлага, төлбөрийн акт, эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн гэж үзвэл эрх бүхий албан тушаалтанд гомдол гаргах эрхтэй"

<sup>8</sup> Төрийн аудитын тухай хуулийн 42.1-т энэ хуулийн 16 дугаар зүйлд заасан этгээд, хүчин төгөлдөр болсон албан шаардлага, төлбөрийн актыг хугацаанд нь биелүүлээгүй, аудитын үйл ажиллагаанд саад учруулсан, санхүүгийн тайлангийн аудитаар сөрөг дүгнэлт авсан, хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан, албан үүргээ биелүүлээгүй, албан тушаалын бүрэн эрхээ хэтрүүлсэн нь аудитаар илэрсэн бол тухайн албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно